



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 23 өдөр

Дугаар А/98

Чингис хот

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.1-ийн "а", Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.1, 58.2.20, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.3.5, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хоёрдугаар хуралдааны 2020 оны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хууль зүй, дотоод хэргийн сайдын Хэнтий аймгийн Засаг даргатай 2021 онд хамтран ажиллах талаар байгуулсан гэрээ, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.3.5.6 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Шүүхийн шийдвэр гүйцэтгэх 419 дүгээр нээлттэй хорих ангид сургалтын байр барихад 13 000 000 /арван гурван сая/ төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга /Б. Дарханбаатар/ нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010289